

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар
сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан
"Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт



МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2026/01/01-ний өдрөөс 2026/06/30-ны өдрийг дуустал.
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: МОСТ Финтек ХК Регистр: 5220351 Хувийн хэргийн дугаар: 9007001021 Үнэт цаасны код: MOST Утасны дугаар: 7505-2727
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Төлбөр тооцооны дэвшилтэт технологи /6311/
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	485,969,700
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч: Н.Урнаа Хянасан: Гүйцэтгэх захирал С.Оргил

1.

Хагас жилийн санхүүгийн тайлан
/хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт		Үлдэгдэл	
			2026 оны 01-р сарын 01	2026 оны 06-р сарын 30
	ХӨРӨНГӨ			
	Эргэлтийн хөрөнгийн дүн		7,516,482,390	8,730,583,324
	Эргэлтын бус хөрөнгийн дүн		11,686,898,834	11,793,061,828
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		19,203,381,225	20,523,645,151
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн		448,293,187	533,427,094
	Урт хугацаат өглөгийн дүн		111,382,368	107,221,498
	Эздийн өмчийн дүн		18,643,705,670	19,882,996,560
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		19,203,381,225	20,523,645,151	

Орлогын тайлан	Үзүүлэлт		Тайлант үеийн дүн	
	Борлуулалтын орлого (цэвэр)		2,427,583,978	
	Борлуулалтын өртөг		(123,710,759)	
	Нийт ашиг (алдагдал)		2,303,873,219	
	Хүүний орлого		283,962,171	
	Үйл ажиллагааны нийт зардал		(1,140,888,800)	
	Бусад орлого/зардал		(46,612,638)	
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		1,400,333,952	
	Орлогын татварын зардал		139,812,081	
	Татварын дараах ашиг (алдагдал)		1,260,521,871	

Өмчийн өөрчлөлтийн тайлан	ҮЗҮҮЛЭЛТ	2026 оны 01-р сарын 01	2026 оны 06-р сарын 30
	Өмч	4,859,697,000	4,859,697,000
	Халаасны хувьцаа	(272,160,007)	(272,160,007)
	Нэмж төлөгдсөн капитал	6,795,689,845	6,795,689,845
	Хөрөнгийн дахин унэлгээний нэмэгдэл	4,186,049,897	4,148,602,063
	Хуримтлагдсан ашиг	3,074,428,936	4,351,167,660
	Нийт дүн	18,643,705,670	19,882,996,560

Мөнгөн гүйлгээний тайлан	ҮЗҮҮЛЭЛТ		Тайлант үеийн дүн	
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		1,138,802,050	
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(306,749,142)	
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-	
	Валютын ханшийн зөрүү		1,430	
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		832,054,337	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		682,285,678	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,514,340,016	

2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	<i>МОСТ Финтек ХК-ийн Аудитын хороо нь 2026 оны хагас жилийн санхүүгийн тайлан, бүртгэл нь Монгол улсын хууль тогтоомж, компанийн дүрэмд нийцсэн хэмээн дүгнэсэн. /Хорооны дүгнэлтийг хавсаргав/</i>	
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<i>Цэвэр ашгийн хувь – 51.92% Нийт хөрөнгийн өгөөж ROA 6.35% Өөрийн хөрөнгийн өгөөж ROE 6.54%</i>
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<i>Эргэлтийн харьцаа 16.37 Төлбөрийн чадварын харьцаа 165.35</i>
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	<i>Монголбанкнаас 2023 онд гаргасан Монгол улсад мөрдөгдөх нэгдсэн QR-ын стандарт үйлчилж эхэлсэнтэй холбогдуулан шинэ стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ ажлын хүрээнд бүхий л QR гаргагч санхүүгийн болон оператор байгууллагуудтай харилцан холболт шинэчлэх, шинээр холбогдох ажлыг хийсээр байна. Зохицуулагч байгууллагаас гаргасан журам нь зөвхөн санхүүгийн байгууллагын хүрээнд хэрэгжихээр заагдсан байгаа нь бусад QR гаргагч оператор байгууллагуудтай харилцан холболт хийхэд ихээхэн хүндрэл учруулсан хэвээр байна. МАБ-ын хүрээнд ISO27001 сертификатын хугацаа дуусч, олон улсын аудитад орж амжилттайгаар сунгуулсан.</i>
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	<i>МОСТ Финтек ХК нь НБББББ-н дагуу санхүү бүртгэлээ хөтөлж байгаа тул санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэсэн ажил гүйлгээ байхгүй болно.</i>
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2026 оны эхний хагас жилийн хугацаанд дараах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг олгов. /Зөвшөөрөл олгосон ТУЗ-ийн тогтоолыг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлэв/ 1. Ард Кредит ББСБ ХК-тай “Хамтын ажиллагааны гэрээ” 2. Эдванс Кредит ББСБ ХХК-тай “Хамтын ажиллагааны гэрээ” 3. Эдванс Кредит ББСБ ХХК, “ГрэйпСити Монгол” ХХК, “МОСТ Финтек” ХК нарын гурвалсан гэрээ “Программ хөгжүүлэлтийн гэрээ” 4. “ГрэйпСити Монгол” ХХК-тай “Програм хангамж түрээсээр ашиглах гэрээ” 5. “ГрэйпСити Монгол” ХХК-тай байгуулах “Хамтран ажиллах гэрээ” <i>Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.</i>	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	<i>Тайлант хугацаанд олон нийтэд хувьцаа санал болгоогүй.</i>	

6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	МОСТ Финтек ХК нь засаглалын хувьд дараах тогтолцооны дагуу үйл ажиллагаа явуулдаг бөгөөд компанид дараах эрх бүхий институт болон албан тушаалтнууд ажилладаг болно.  Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дуусгавар болсон. Ийнхүү дуусгавар болж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн дэргэдэх ЗНДЦУ-н хороо нь Компанийн тухай хуульд заасны дагуу нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд шууд нэр дэвшүүлсэн. Нэр дэвшигчдээс компанийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хамгийн олон санал авсан дараах гишүүдийг компанийн дүрэмд заасны дагуу 2 жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар сонгосон. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр: 1. Сангидаасүрэн овогтой Сүхболд 2. Ганбаатар овогтой Тэлмэн 3. Болдбаатар овогтой Баатармөнх Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр: 1. Авир овогтой Сүхдорж 2. Чулуун овогтой Ганхуяг 3. Баасандорж овогтой Мөнхцэцэг 4. Сүхдорж овогтой Оргил 5. Энхбат овогтой Мөнхсаруул 6. Чулуун овогтой Алтан-Өлзий
7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл Хувьцаа эзэмшигчдийн хурал: Тайлант хугацаанд нийт 1 удаа ээлжит хурал зохион байгуулагдан хуралдаж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн. Үүнд: 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлав. 2. ТУЗ-ийн 2026 оны төсөв батлав. 3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, шинээр гишүүд сонгов. Хурлын шийдвэрүүдийг болон холбогдох хуульд заасан бусад материалуудыг Санхүүгийн зохицуулах Хороо, Биржид хүргэж, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажилласан.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал: Компанийн ТУЗ тайлант хугацаанд нийт 3 удаагийн хурлаар нийт 12 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн эчнээ санал хураалтаар:

- ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.
- Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.
- ТУЗ-ийн дэргэдэх Бизнесийн бодлогын хорооны ажиллах журмыг баталсан.

2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хурлаар:

- Компанийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах шийдвэрийг гаргасан.
- Гүйцэтгэх захирлын 2025 оны ажлын үр дүнг дүгнэсэн.

2026 оны 06 дугаар сарын 29-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд шинээр сонгогдсоны дараа эхний хурлаа танхимаар 100%-ийн ирцтэйгээр амжилттайгаар хийж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:


- ТУЗ-ийн даргаар А.Сүхдоржийг нийт гишүүдийн 100%-ийн саналаар сонгов.
- ТУЗ-ийн НБД Э.Цэлмэгийн ажил үүргийг хэвээр үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтов.
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц бүрэлдэхүүнийг дараах байдлаар тогтов.
 1. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо
Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Баатармөнх
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Тэлмэн
ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Ганхуяг
 2. Аудитын хороо
Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Тэлмэн
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Сүхболд
ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Алтан-өлзий
 3. Бизнесийн бодлогын хороо
Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Сүхболд
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Баатармөнх
ТУЗ-ийн ердийн гишүүн Э.Мөнхсаруул
- Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 0.15% болох 715,208 ширхэг энгийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэв.
- Сонирхлын зөрчилтэй нийт 5 хэлцлийн нөхцөл, болзлыг тогтон, гэрээ хийх зөвшөөрлийг Гүйцэтгэх удирдлагад олгов.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Бизнесийн бодлогын хороодыг байгуулсан бөгөөд хороодын даргаар хуульд заасан шаардлагыг хангасан Хараат бус гишүүдийг ажиллуулахаар томилсон.

Удирдах зөвлөлийн хурал: Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бүрэн эрхийг гүйцэтгэх захиралд олгосон бөгөөд компанийн зарим чухал шийдвэрийг зөвлөлдөх зарчмыг баримтлан удирдах зөвлөлийн хурлаар долоо хоног бүрийн даваа гарагт хэлэлцэн шийдвэрлэдэг.

Компанийн 2025 оны засаглалын тайланг 2026 оны 2 дугаар сарын 26-ны өдөр Lkhagvamyadag@frc.mn хаягт хүргүүлэн ажилласан.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:  Норжий овогтой Урнаа
Албан тушаал: Захиргаа, санхүүгийн газрын Захирал
Гарын үсэг: 
Огноо: 2026 оны 7 дугаар сарын 20-ны өдөр